



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/490

Алтай хот


**Газар эзэмших эрхийн гэрчилгээний
 дуудлага худалдааг дахин зарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн Засаг даргын 2022 оны А/295 дугаар захирамжаар зарлагдсан Есөнбулаг сумын “Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүсэд хавсралтад дурдсан 2 нэгж талбар газарт газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг дахин зарлан явуулсугай.


2.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэх газруудад архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулж мөрдүүлэхийг аймгийн ерөнхий архитектор (Б.Бямбадорж)-т, дуудлага худалдааг 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр цахимаар зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2012 оны
08 дугаар сарын 11-ны өдрийн 4/1 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ОЛГОХ ГАЗРЫН БАЙРШИЛ,
ЗОРИУЛАЛТ, ХЭМЖЭЭ, ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ
АНХНЫ ҮНЭ**

№	Газрын байршил	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Зориулалт	Талбайн хэмжээ (м2)	Дуудлага худалдааны анхны үнэ (мян.төг)
1	Индэрт баг	2550964	Тэжээл, бордооны агуулах	1000	3000.0
2	Жаргалант баг	2550956	Худалдаа үйлчилгээ	500	5000.0

__оОо__